

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-10</i>

1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	3-8
2.Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан	хойшлов
3.Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан	8-10

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 27 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жавхлан, Д.Өнөрболор;

Чөлөөтэй: Ш.Раднаасэд;

Тасалсан: Ц.Анандбазар, Х.Булгантуяа, Л.Мөнхбаатар, Ч.Хүрэлбаатар.

Нэг.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19.3.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.6.Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох 1 удаагийн тэтгэмж” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан ажлын хэсгийн бүрэлдэхүүн дутуу тул уг асуудлыг хойшлуулав./14:49/

Гурав.Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан ажлын хэсгийн бүрэлдэхүүн дутуу тул уг асуудлыг хойшлуулав./14:52/

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 26 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим,
14 цаг 27 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Төсвийн байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Та бүхэнд өнөөдрийн хуралдааны ирцийг танилцуулъя.

Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн Баделхан, Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Улсын Их Хурлын гишүүн Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Төсвийн байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүдэд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 3 асуудал байгаа.

1 дүгээрт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2023

оны 10 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг хийхээр байгаа.

2-т, Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан,

3-т, Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүтгэсэн аудитын тайлан гэсэн 3 асуудал байна

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё. 1 дүгээр асуудал.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2023 оны 10 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг байгаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танхимд оруулаарай. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж байя. 1 дүгээр асуудалтай холбогдуулаад Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулж, Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэрсийг танилцуулъя, та бүхэнд.

Содномын Чинзориг Эрүүл мэндийн сайд, Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Дангаагийн Баярболд Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга, Лхагважавын Мөнхцэцэг Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын Санхүү даатгалын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр хүрэлцэн ирж байгаа юм байна.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 сарын 07-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг шинэчлэн батлахдаа 2 салгаж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль. Энэ хуулиудыг 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн. Ингээд 2023 оны 10 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 19.3.6 дахь заалтын ишилсэн зохицуулалтыг шинээр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуультай нийцүүлэн анхны хэлэлцүүлгийг дахин хийх шаардлагатай гэж Улсын Их Хурлын чуулган дээр бас нэгдсэн хуралдаан дээрээс үзсэн.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулъя.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд гишүүд хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулж хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асууж болно гэж заасан байгаа.

Ингээд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Байнгын хороонд бичгээр ирүүлсэн зарчмын зөрөөтэй саналын томъёолол байна.

Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Чинзориг сайдаас гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёолол байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 19.3.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.6 тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй таслал амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн. Таслалгүй юм байна. Би эхнээс нь дахиад уншаадахъя. 19.3.6 Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмж гэсэн ийм зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг Эрүүл мэндийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Чинзориг сайд гаргаж байгаа юм байна. Энэхүү гаргаж байгаа зарчмын зөрөөтэй саналын томъёололтой холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Одонтуяа гишүүн асуулт асууя. Одонтуяа гишүүнээр тасаллаа.

С.Одонтуяа: Чинзориг сайд аа, энэ тодруулах зүйл байна. Сая нэг донорын асуудал дээр энэ гарсан шүү дээ, ингээд юуг нь тэтгэмжийг нь авах гэсэн чинь нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй байна гээд өгөөгүй гээд. Тэгэхээр одоо тэрнээс үл хамаараад энэ тэтгэмжийг өгдөг болъё гэсэн ийм санааг оруулж байгаа юм уу. Энэ ямар...

Г.Тэмүүлэн: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Чинзориг сайдын микрофоныг хүргэе.

С.Чинзориг: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхдээ намрын асуудал чинь ийм л асуудал болсон юм байна лээ. Одоо нийгмийн даатгалынх нь тухай хуулиар болохоор нийгмийн даатгалын шимтгэл 36 сараас доошгүй хугацаанд шимтгэл төлсөн амьгүй донорт тэр тэтгэмж олгогдох хууль байгаа юм. Тэр намрын тэр хүний тохиолдол дээр энэ 36 сарын тэтгэмж төлөөгүй, 10 сарын тэтгэмж төлсөн хүн байсан учраас хуульд заасан шаардлага хангахгүй байна гээд

тэтгэмж өгөхгүй гээд үүнээс болоод нэлээн маргаан болсон юм.

Одоогийн би энэ тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа асуудал нь болохоор тэр Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэл төлсөн байх хугацааг хангаагүй л бол энэ тусгай сангийн хуулиар Эрүүл мэндийг дэмжих сангаасаа тэр амьгүй донорт олгох тэтгэмжийг нь олгодог байя гэж.

Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 36 ба түүнээс дээш сарын шимтгэл төлсөн, тэр нийгмийн даатгал сангаас тэтгэмж авах эрх нь үүссэн хүн амьгүй донор болбол Нийгмийн даатгалын сангаас авна. Тэр даатгалын сангаас тэтгэмж авах эрх нь үүсэхгүй байгаа амьгүй донорт манайх энэ тусгай сангийнхаа хуулиар Эрүүл мэндийг дэмжих сангаасаа оруулдаг болгож байгаа.

Тэр орхигдчихсон байсан асуудлыг нь энэ хуулиараа нөхөж өгч байгаа ийм л асуудал зохицуулалт оруулж байгаа юм. Тэгэхээр даатгалын сангаас тэтгэмж авах эрх нь үүссэн нь бол Нийгмийн даатгалын сангаас авна. Тэр шимтгэл төлөх хугацаа нь 36 сар хүрэхгүй байгаа буюу ерөөсөө нийгмийн даатгалын шимтгэл төлөгч биш байсан бол энэ нөгөө эрүүл мэндийг дэмжих сангаасаа тэтгэмжийг нь авдаг болгож, ийм зохицуулалт оруулж өгч байгаа юм.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Үгүй ээ, бид амьгүй донороос тодорхой эд эрхтэн авах тухай л юм ярьж байна шүү дээ. Тэгээд тэр нь шимтгэл төлсөнтэй холбогдохын утга учир ер нь юунд байгаад байгаа юм? Үнэхээрийн тэр авах гэж байгаа зүйлс нь бусдын эрүүл мэнд, амь насанд үнэхээрийн л хэрэгтэй л байгаа юм бол түүнийг чинь зохих юу гэдэг юм, төлбөр гэдэг юм уу юм өгөөд авч болохгүй юм уу? Тэгээд энэ чинь их л

сонин л ойлголт болох гээд байна шүү дээ. Үүн дээр нэг тайлбар өгөөч.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Чинзориг сайд.

С.Чинзориг: Уг санаа нь бол Батжаргал гишүүний яриад байгаа санаа уг нь зөв байгаа юм. Тэр амьгүй донор чинь бусдын амь насыг аврахад өөрийнхөө эд эрхтнийг л өгч, амь насыг нь аварч байгаа асуудал. Тийм учраас тэр даатгалын шимтгэл төлөгч байсан уу, үгүй юү гэдгээс үл хамаараад төлбөрийг нь өгч байх асуудлыг зохицуулмаар л байна гэдэг зарчим нь уг нь бол зөв байгаа юм. Гэхдээ энэ дээр 2 юм байгаа юм.

1 дэх асуудал нь бидний баталчихсан Нийгмийн даатгалын хуулиар чинь бол 01 сарын 01-нээс хэрэгжинэ шүү дээ, түүгээр чинь тэр 36 сараас дээш жилийн шимтгэл өгч байсан бол тэр нас барсан иргэнийг гэр бүлийн гишүүнд нь тэтгэмж олгох асуудал Нийгмийн даатгалын хуулиар зохицуулагдаад явчихсан юм. Тэгэхээр би бол орхигдоод байгаа тэр 36 хүртэл сар шимтгэл төлөөгүй юм уу эсвэл ерөөсөө шимтгэл төлөгч биш ийм амьгүй донор гарвал гэр бүлд нь тэр тэтгэмжийг нь энэ тусгай сангаасаа олгодог байя л гэж байгаа юм.

Гишүүд нэг юмыг нэлээн сайн бас зөв ойлгомоор юм байна лээ. Ер нь олон улсад ч гэсэн тэр энэ эд эрхтэн шилжүүлж авахдаа өндөр тийм төлбөрөөр юм уу, худалдаж авна гэсэн асуулт л ерөөсөө үүсгэж болохгүй юм байна лээ. Худалдаж авна л гэвэл энэ тэгээд нөгөө далд хүний эд эрхтний наймаа буруу юм руу явах тийм асуудал үүсдэг.

Тийм учраас энэ дээр бас нэлээн болгоомжтой хандах ёстой. Хэт өндөр үнээр бас үнэлж авах тухай эд нар асуудал бас ярих нэг их тийм зохимжтой

биш юм байна гэж бас үздэг юм байна лээ. Тийм учраас бол бид нар энэ хуулиар тэр ядаж орхигдоод байгаа шимтгэл төлөх хугацаанд шаардлага заасан хугацаанд хүрэхгүй байгаа, ерөөсөө шимтгэл төлөгч биш байсан амьгүй донор гарвал тэр гэр бүлд нь тэтгэмж олгодог байх нь энэ тусгай сангаасаа олгодог зохицуулалтаа олгоё л гэж л. Тэгээд даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн нь бол тэндээсээ аваг, эрх үүсэхгүй нь энэ Эрүүл мэндийг дэмжих сангаасаа бид нар олгодог байя л гэдэг.

Намрын хүн чинь зайлуул, тийм л юм гарсан шүү дээ. 10 сарын шимтгэл төлөгч байсан учраас даатгалын сангаас тэтгэмж авах эрх нь үүсээгүй байна гээд л. Тэгээд л бөөн маргаан нь их болсон асуудал. Тийм учраас энэ цоорхойг нь энэ хуулиараа бид нар нөхөж өгье л гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Чинзориг сайд аа, би үүнийг зүгээр дахиад таны гаргаж байгаа зарчмын зөрөөтэй саналын томьёолол дээр нь тодруулаад асуугаадахъя. Саналын томьёолол та бичиж өгснөөр 19.3.6 тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмж гээд орчихсон байгаа. Өмнөх нь ямар бичиглэлтэй байсан бэ гэхээр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй гэж байгаа юм. Эс үгүй бол тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмж гэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр чинь логик нь яг бичвэр талаасаа зөв гарч байна уу, үгүй юү. Таны гаргасан саналын томьёолол дээр. Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох 1 одоогийн тэтгэмж.

Шимтгэл төлөлт нь шимтгэл төлж байгаагүй ч гэдэг юм уу хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүд гэхээр чинь яг яалт ч үгүй тэр шимтгэл төлөлт чинь өөрөө энэ донортой хамаараад байгаа юм уу? Тэгэхээр бичвэр талаасаа яг зөв болж байна уу, үгүй юү? Яг ажлын хэсгийнхэн та хэд, Эрүүл мэндийн яамныхан бас энэ дээр томьёолол дээр нь анхаарч үзэж харсан уу? Би бол уншигдах талаасаа ч, логик талаасаа ч нэг л буруу л болоод байх.

Чинзориг сайд тайлбар өгөх үү, та.

С.Чинзориг: 2 юм байгаа юм. Одоогийн хүчин төгөлдөр байгаа хуулиар Нийгмийн даатгалын хуулиар бол амьгүй донорт оршуулгын тэтгэмж олгоно гэсэн ийм хуулийн заалт байгаа юм. Одоогийн хуулиар. 24 оны 01 сарын 01-нээс хэрэгжих нөгөө бидний баталсан Нийгмийн даатгалын багц хуулиар чинь оршуулгын тэтгэмж гэдгийг нь байхгүй болгоод, нас барсан иргэний гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж гээд ингээд томьёолоод явчихсан юм байна. Тэгэхээр би үүнийгээ нөгөө өмнөх хууль өргөн барихдаа энэ оршуулгын тэтгэмж гэж оруулж ирснийгээ өөрчилж, тэр Нийгмийн даатгалын шинэ хуультай уялдуулаад гэр бүлийн гишүүнд нь олгох нэг удаагийн тэтгэмж гэж оруулж ирж байгаа юм.

2 дахь асуудал нь даатгалын сангаас даатгалын санд шимтгэл төлсөн байх хугацааг хангаагүй гээд ингээд оруулчих юм бол тэр 36 сар хүртэл шимтгэл төлөөгүй байсан хүн нь ч орох юм байна. Ерөөсөө шимтгэл төлөгч бус, биш байсан хүн ч орчихно гэж л би тооцоод эсвэл наана чинь манай ажлын албаныхан бол хугацаанд заасан тэр хууль нь хуулийн заасан хугацаа хангаагүй эс үгүй бол шимтгэл төлөгч биш байсан бол гэж оруулсан байсныг би тэр шимтгэл төлөгч биш байсан бол гэдгийг нь дарчхаад байгаа юм.

Хангаагүй л гэх юм тэгээд дутуу сартай байсан ч, ерөөсөө шимтгэл төлөгч биш байсан ч орчих юм байна. Тэгээд яах яах вэ, тэр журмыг нь Засгийн газар батлах юм. Тэгээд түүн дээрээ тэр ерөөсөө шимтгэл төлөгч биш байсан энэ тэрийг тодруулаад оруулчихаж болох уу гэж бодоод байгаа юм.

Би тэгээд эс үгүй бол шимтгэл төлөгч биш байсан гэдгийг заавал оруулах шаардлагагүй бол би сая би дарчихаад л байх юм.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Одонтуяа гишүүн горимын санал гаргах юм уу, та.

С.Одонтуяа: Чинзориг сайд аа, ийм толгой эргүүлсэн юм хийж байхаар ингэчихвэл яасан юм. Одоо шууд донорынхоо угаасаа он гартал цаг байна шүү дээ. Донорын хуульдаа өөрчлөлт оруулаад л амьгүй донорт нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоно гэххээд л тэгээд 1 тэр хуультай чинь уялдуулаад дагалдах хууль өргөн баригддаг шүү дээ. Түүн дээр нь та нийгмийн даатгалын нөгөө хуульд орчихсон нөгөө тэдэн хувь төлсөн бол гэдэг л заалтаа л хасчихгүй юу. Амьгүй. Тэгэхээр чинь л даатгалтай огт хамаарахгүйгээр л тэр хүн нэг удаагийн тэтгэмж авна гэдэг чинь л ганц л хууль дээрээ зохицуулаад болчих юм биш үү? Одоо ингээд л толгой эргүүлсэн. Нэгэнтээ л бүгдэд нь өгөх юм бол төлсөн бол, төлөөгүй бол гээд ингээд будилуулж байхаар зүгээр та донорынхоо хуульдаа л өөрчлөлт оруулаад л тэрэнтэй уялдаад л нийгмийн даатгалын тэр заалтаа л хасчихгүй юу. Тэгэхгүй бол энэ чинь нэг толгой эргэ ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Одонтуяа гишүүн нөгөө энэ Засгийн газраас өргөн баригдсан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай байгаад байгаа юм. Тэгээд таны ярьж байгаа донорынх гэхээр чинь нөгөө өргөн баригдаагүй, хөндөгдөөгүй асуудал болчих гээд байгаа юм. Тэгэхээр энэ хууль дээрээ л бид нар өөрчлөлтүүдээ хийгээд

явах л ийм л саналтай байгаад байгаа юм.

Чинзориг сайд тодруулах юм уу, тайлбар нэмээд хэлчихье.

С.Чинзориг: Тэгээд Донорын хууль чинь өргөн бариагүй, хөндөгдөөгүй асуудал биш ээ. Донорын хуульд оруулаад батална гэдэг асуудал бол дэгээрээ бол байхгүй.

2 дугаарт, Донорын хууль Засгийн газар луу өргөн барьж оруулаагүй байгаа учраас 01 сарын сарын 01-ний дотор батлуулаад, хэрэгжүүлнэ гэхэд бол хэцүү л дээ. Энэ дээр толгой эргээд байх юм уг нь байхгүй л гэж би ойлгоод байгаа юм. Нийгмийн даатгалын санд шимтгэл төлсөн байх тэр хугацаа нь хангасан донор байх юм бол тэр даатгалын сангаасаа авна. Тэр хугацааг хангаагүй байх юм бол энэ Эрүүл мэндийг дэмжих сангаасаа авна л гээд ингээд ялгаж өгч байгаа юм шүү дээ. Нэг их тийм толгой эргээд байх юм байхгүй л гэж би ойлгоод байгаа юм.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Тэр нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн тэр заалтыг хангаагүй амьгүй донорт нэг удаагийн тэтгэмж олгоно гээд л хэлчихвэл болж байгаа юм биш үү, ер нь. Эрүүл мэндийн дэмжих сангаасаа. Үгүй ээ, үгүй харин тэр заавал урьд нь тэр шимтгэл төлсөн хугацааг хангаагүй бол энэ тэр гэж байхын оронд. Тэдийн тэд дэх заалтыг нь хангаагүй амьгүй донорт нэг удаагийн тэтгэмж олгоно гээд л хэлчихвэл амар юм биш үү? Тийм.

Г.Тэмүүлэн: Ойлголоо.

Одоо санал хураалтаа явуулцаая. Би та бүхэнд томьёоллыг нь дахиад уншаад танилцуулаадахъя.

19.3.6 Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмж. Зарчмын зөрөөтэй саналын томьёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн Чинзориг гэсэн ийм томьёолол байна.

Гишүүд Чинзориг гишүүний гаргасан зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд санал хураалтыг явуулъя. Чинзориг гишүүний гаргасан зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор. Санал хураалт.

66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу? Зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баделхан дарга, Баделхан гишүүн та танилцуулчих уу? Баделхан дарга танилцуулъя.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

14.46 цаг

Дараагийн асуудалдаа оригооё. 2 дахь асуудал.

Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаар гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Үндэсний аудитын газраас танилцуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэрс байна уу? Эхлээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сангийн яамнаас хүмүүс байна уу? Сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар хаана байна?

Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаар аудитаас гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэх байгаа.

Татварын ерөнхий газрын дарга Заябал дарга байгаа юу, байна. Сангийн яамны сайд, дарга нар байна уу? Гадаад томилолт, хэзээ ирэх вэ? Дэд сайд, төрийн нарийн.

4 номер. Сайд, дэд сайд, төрийн нарийн хаагуур байгаа бол? Тайлбар. Ажлын хэсгийн 4 номер.

Б.Тэлмүүн: Сайн байна уу? Сангийн сайд гадаадад томилолттой явж байгаа. Сангийн дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга хурал давхацчихсан гээд. Дэд сайд Үндэсний хорооны хуралд байж байна гээд тэгсэн.

Г.Тэмүүлэн: Сангийн яамныхан Байнгын хороонд дэд сайд, төрийн нарийнаа дууд аа. Дараагийн асуудал хэлэлцэж байх хооронд танай дэд сайд, төрийн нарийн нар орж ирэхгүй бол танай асуудлыг хойшлуулна.

Татварын шинэчлэлтэй холбоотой Сангийн яамнаас 2019 онд хэрэгжүүлсэн, батлуулсан хуулийн шинэчлэлтэй холбогдуулж аудитаас гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэх байгаад байгаа. Тэгэхээр сайд нь гадаадад томилолттой байж болно. Дэд сайд, төрийн нарийн нар нь заавал ч үгүй Байнгын хорооны хуралдаанд ирж, энэ аудитын тайлантай танилцаж,

асуултад хариулж оролцох ёстой байгаад байгаа.

2 дугаар асуудлыг хойшлууллаа. Дэд сайд, төрийн нарийн нарийн нараа дуудацгаа.

3 дахь асуудалдаа оръё.

Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний Аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэж эхэлье.

Аудитынхан, аудитын газрынхан байна. Уул уурхайн яамнаас ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэн хэн байна. Агентлагийн дарга Баярмандал дарга байна уу, байна. Уул уурхайн яамнаас удирдах албан тушаалтан ямар хүн байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батболд. Уул уурхайн яамны сайд, дэд сайд, Төрийн нарийн аль хуралд, хаана сууж байна.

Микрофон дээр тайлбар мэдээлэл өг дөө. 4 номер.

Н.Батболд: Өдрийн мэнд хүргэе. Уул уурхайн яамнаас. Сайд, Төрийн нарийн бичгийн дарга 2 нэг ажлын хэсгийн хуралтай суугаад байна. Түлшний яаралтай.

Г.Тэмүүлэн: Дэд сайд, төрийн нарийн, сайд, дарга нараа дуудацгаа.

Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайланг бас хэлэлцэх байгаад байгаа.

Бид нар өмнөх 7 хоногт Улсын Их Хурлаас Даргын зөвлөл дээрээс энэ 2 асуудлыг баталсан. Холбогдох яам болоод агентлагуудад холбох мэдээллийг хүргүүлсэн. Холбогдох албан тушаалтнуудыг өнөөдрийн Байнгын хуралдаанд заавал ч үгүй ирж, оролцох

зарыг, үүрэг даалгавар чиглэлийг бас өгсөн байгаа. Яагаад дэд сайд, төрийн нарийн нар хуралдаанд ирж оролцохгүй байна вэ? Яагаад хүндэтгэлтэй хандахгүй байна вэ? Байнгын хороо дээр.

Дэд сайд, төрийн нарийн нараа дараагийн хурал дээр заавал ч үгүй ирж оролцох даалгаврыг өгч байна, Байнгын хорооноос. Заавал ч үгүй та бүхэн энэ хуралд оролцож энэ асуудлууд дээр холбогдох тайлбар, мэдээллүүд өгөх ёстой. Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах ёстой.

Чухал асуудлууд байгаа. Уул уурхайн орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудлууд, Сангийн яам Татварын шинэчлэлтэй холбоотой асуудлууд байна.

Энэ асуудлууд дээр Улсын Их Хурлаас, Төсвийн байнгын хорооноос Улсын Их Хурлын гишүүдээс лавлаж, тодруулах, аудитын дүгнэлтийн хэрэгжилтийг хангуулах асуудлууд бас чухал байгаа. Тулгамдаж байгаа. Энэ асуудлыг бас хойшлууллаа. Дараагийн хурал дээр зөвхөн Сангийн яам биш, Уул уурхайн яам биш, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар бас энд оролцож, энэ аудитын тайлан түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хийсэн ажлуудаа бас танилцуулах ёстой байгаа шүү. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарт бас зарыг хүргээрэй. Энэ асуудлыг хойшлууллаа.

Ингээд холбогдох яамны дэд сайд, төрийн нарийн нар Засгийн газрынхны бас хариуцлагагүй асуудал болж энэ 2 асуудал хойшилж байна.

Дараагийн Байнгын хороо хүртэл эдгээр асуудлуудыг хойшлуулж байна.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан байна.

*Байнгын хорооны хуралдааны
ирцэд орсон Улсын Их Хурлын гишүүдэд
баярлалаа.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

П.ОЮУНГЭРЭЛ